



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 123,093,586.00 (нэг зуун хорин гурван сая ерэн гурван мянга таван зуун наян зургаан) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөгчийг оролцуулан ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 07
дугаар сарын 08-ний өдрийн
30.0 дугаар тогтоолын хавсралт

**Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах
хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэр лэсэн он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
Говь-Алтай Нисэх буудал				
1	ТМХ20 маркийн, ачаа ачигч трактор 5163 УБ улсын дугаартай	1999.12.21	61,195,700.00	2,000,000.00
Дорнод Нисэх буудал				
2	SF-220 маркийн жижиг трактор, 6631 УБ улсын дугаартай	2010-04-01	5,000,000.00	2,500,000.00
Өмнөговь Нисэх буудал				
3	Хьюндай Старекс маркийн, 5700 УБН улсын дугаартай, арлын дугаар- KMJWWN7HP5U66119 2	2005	25,500,000.00	3,000,000.00
Увс Нисэх буудал				
4	Киа Оптима маркийн, суудлын автомашин 7222 УВХ улсын дугаартай, KNAGE227295312966	2008	31,397,886.00	3,000,000.00
Бүгд дүн			123,093,586.00	10,500,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			(нэг зуун хорин гурван сая ерэн гурван мянга таван зуун наян зургаан)	10,500,000.00 (арван сая таван зуун мянган)